



МУИС-ийн дэргэд
байгуулагдсан
**ГАРААНЫ
КОМПАНИУД**



ГАРААНЫ ВЕРТЕКС ГАЗ ХХК

Үүсгэн байгуулагч: Профессор Б.Энхсаруул
ШУС, БУС, Химийн тэнхим

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА:

Тус гарааны компани нь шатах ашигт малтмалын хими, энергийн эх үүсгэврийн химийн боловсруулалтын чиглэлээр мэргэшсэн эрдэмтдийн олон жилийн турш хуримтлуулсан мэдлэг чадвар дээр үндэслэн байгуулагдсан. Эх орныхоо цэвэр эрчим хүчний технологи боловсруулалт, шинэ хийн түлшний үйлдвэрлэл болон хэрэглээг монгол улсад нэвтрүүлэхэд манай компанийн зорилго оршино. Манай орон хийн түлшний байгалийн нөөц байхгүй боловч, түүнийг хямд, хаягдаж буй нүүрснээс гарган авах бүрэн боломжтой юм. Багш, оюутны хамтарсан Инновацийн төслийг амжилттай хэрэгжүүлж Багануур, Таван толгойн ордуудын нүүрснээс байгалийн хийн түлшийг гаргах судалгааг хагас үйлдвэрлэлийн түвшинд гүйцэтгэсэн. Монгол улсад цэвэр хийн түлшний хэрэглээ өргөнөөр нэвтэрснээр орчны агаарын бохирдлын асуудлууд бүрэн гүйцэд шийдвэрлэгдэх боломжтой болно.

Бид сүүлийн жилүүдэд илчлэг өндөртэй байгалийн хийг гаргах каталитик синтезийн судалгааг эрчимтэй явуулж, нүүрсний хийг 99% метан хийд хувиргах идэвхтэй катализаторыг гарган авч чадсан. Цаашид энэхүү сонгомол үйлчлэлтэй катализаторын оролцоотойгоор нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх практик нөхцөл дэх туршилтуудыг энэхүү Инновацийн төслөөр гүйцэтгэх зорилготой юм. Уг төслөөр гарган авах бүтээгдэхүүн нь зах зээл дэх импортын бүтээгдэхүүнийг орлож, шаталтаас үүсэх хорт бодисын хэмжээг бууруулах, эдийн засгийн хэмнэлттэй, цэвэр, аюулгүй, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн байх болно.



Монгол улсад цэвэр хийн түлшний хэрэглээ өргөнөөр нэвтэрснээр орчны агаарын бохирдлын асуудлууд бүрэн гүйцэд шийдвэрлэгдэх боломжтой болно.



Судалгааны багийн гишүүд:

- Б.Буян-Өлзий ШУС, Хими, Магистрант
- Б.Ариунжаргал ШУС, Хими, Магистрант
- Х.Барсболд ШУС, Хими, Магистрант
- Б.Нямсүрэн ШУС, Хими, Магистрант
- Т.Баасанжаргал ШУС, Хими, Магистрант
- А.Нямсүрэн ШУС, Хими, 4-р түвшин
- Г.Сувданчимэг ШУС, Хими, 4-р түвшин
- Б.Отгонномин-Эрдэнэ МУИС, БС, Менежмент, 3-р
- Б.Мөнхтуяа МУИС, БС, Менежмент, 3-р түвшин.

Холбоо барих мэдээлэл

МУИС, Номын сангийн 618 тоот

75754400 - 2469

enkhsharuul_b@num.edu.mn





ГАРААНЫ ДИЖИТАЛ СОЛЮШНС ХХК

Үүсгэн байгуулагч: Профессор. А. Энхбаяр
ХШУИС, Хэрэглээний математикийн тэнхим

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА:

Компьютер график, мультимедиа судалгааны нээлттэй лабораторийг МУИС-ийн дэргэд проф. А.Энхбаяр санаачлан 2015 онд АХБ-ны санхүүжилттэйгээр байгуулсан. Тус лабораторид компьютерийн ухаан, програм хангамж, математик, физик, электроникийн чиглэлийн 10 гаруй оюутан тогтмол судалгаа хийдэг. 2019 оны 5 сард өөрсдийн судалгааны үр дүнд үндэслэн лабораторийн төгсөгч оюутнуудтайгаа хамтран "Дижитал Солюшнс" компанийг байгуулсан. Инновацийн хуулийн хүрээнд "Гарааны" статус авч 3 жилийн хугацаанд заагдсан хөнгөлөлт, дэмжлэгийг авах боломжтой болсон. Бид МУИС-ийн Компьютер график, мультимедиа судалгааны нээлттэй лабораторитай нягт хамтран ажилладаг. Тус лаборатори дахь МУИС-ийн шилдэг оюутан залуусын судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд тулгуурлан компаний бүтээгдэхүүн, хөгжүүлэлтийг хийдэг. Компани хүний нөөцөө лабораторийн шилдэг төгсөгчдөөс бүрдүүлдэг бол нөгөө талаас лабораторийн судалгааг санхүүжүүлж, шинэ гишүүдийн судалгааг чиглүүлж өгдөг. Энэхүү тасралтгүй аргах загвар нь манай компанийн судалгаа, хөгжүүлэлтийн үндэс болдог.




АЛСЫН ХАРАА:

Дэлхийд үнэлэгдэх дижитал шийдлийг хөгжүүлнэ

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Бид боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх дижитал шийдлийг санал болгоно



Судалгааны багийн гишүүд:

П.Наранбаяр, Дижитал Солюшнс ХХК-ийн Зөвлөх, хувьцаа эзэмшигч
Н.Сэвжидпэрэнлэй, Дижитал Солюшнс ХХК -ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал
М.Нямдаваа, Дижитал Солюшнс ХХК-ийн Санхүүгийн зөвлөх
Б.Анхбаяр, Дижитал Солюшнс ХХК-ийн Математик симуляцийн инженер
Ц.Шихихугуг, Дижитал Солюшнс ХХК -ийн Веб хөгжүүлэгч
Магистрант М.Алтаншагай, БС, Бизнесийн менежментийн тэнхим
Профессор Х. Оюундолгор, ХШУИС, МКУТ
Доктор Р.Амартүвшин, ХШУИС, ЭХИТ
Докторант А.Амгалан, ХШУИС МКУТ
Магистрант Н.Бямбажаргал, ХШУИС, МКУТ
Магистрант Б.Батзориг, ХШУИС, МКУТ
Магистрант Б.Намуун, ХШУИС, МКУТ
Магистрант Б.Батзаяа, ХШУИС, МКУТ
Магистрант Г.Бямбасүрэн, ХШУИС, МКУТ
Магистрант Г.Онон, ХШУИС, МКУТ

Холбоо барих мэдээлэл

МУИС, Номын сан 504 тоот

94000133, (11)-330199, 94004217

content@digitalsolutions.mn

www.digitalsolutions.mn,
www.tuuhsyof.com



ГАРААНЫ ЭМ БИ ПИ ЛАБ ХХК

Үүсгэн байгуулагч: Профессор Ж. Батхүү
ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА:

2017 оны 7-р сард проф. Ж.Батхүү нь Гарааны Эм Би Пи Лаб ХХК-ийг үүсгэн байгуулсан. Одоогоор 100% ургамлын гаралтай биологийн идэвхт бүтээгдэхүүн хийх судалгаа-хөгжүүлэлт дээр голчлон ажиллаж байна. МУИС-ийн Био-органик хими-Фармакогнозын лабораторид хийгддэг in vitro screening скрининг судалгааны явцад 2018 онд Залесовын эдгэлж ургамал нь бактерийн эсрэг өндөр идэвхтэй болохыг тогтоосон юм. Ургамлын хоруу чанарын судалгааг Монос Эм судлалын хүрээлэн, бактерийн эсрэг идэвхт нэгдлийн судалгааг Хими, химийн технологийн хүрээлэн, Япон улсын Тохокүгийн анагаах ухаан, эм зүйн их сургууль, Монгол хүний батга үүсгэгч, эмгэгшүүлэгчийн зүйлийн бүрдэл тодорхойлох судалгааг Арьсны өвчин судлалын үндэсний төв, Япон улсын Тохо их сургуультай хамтран гүйцэтгэсэн бөгөөд түүнд агуулагдаж буй фенолт липид нэгдлүүд нь бактерийн эсрэг өндөр идэвхтэй болох нь тогтоогдсон болно.

Залесовын эдгэлж ургамлын ханд агуулсан энэхүү Phyto-acne бэлдмэл нь ижил төрлийн импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад Монгол хүний батга үүсгэгч, эмгэгшүүлэгчийн эсрэг идэвх сайтай, Монгол хүний арьсны онцлогт тохирсон, үнийн хувьд ч өрсөлдөхүйц бүтээгдэхүүн юм.



Судалгааны багийн гишүүд:

Э. Энхцацрал, ХШУИС, ХБИТ
Докторант Б. Батболд, ХШУИС, ХБИТ, Лаборант
Докторант Н. Оюунбилэг, ШУС-БУС, Биологийн тэнхим

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн байр 3А-302
☎ 99051549, 89945037, 99298515
✉ batbold@seas.num.edu.mn,
Oyunbileg0515@gmail.com,
batkhuu@num.edu.mn



ГАРААНЫ МОН БИО ПРО ХХК

Үүсгэн байгуулагч: Профессор Ш.Наранмандах
ШУС-БУС, Химийн тэнхим

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА:

Энэ зорилгоор монгол оронд ургадаг агил мөөг болон каолин шавраас АГАРИЦИНТАЙ ШАВАР БИГНҮҮР бүтээгдэхүүнийг бэлтгэн гаргана. Агаринтай шавар бигнүүр нь нүүрний арьсыг цайруулах, арьсны нүх агшаах, нүүрний арьсны тослогийг тэнцвэржүүлэх, хорыг тайлах, үрчлээ багасгах, батга үрэвслийг эмчлэх зэрэг үйлчлэлтэй.

Агаринтай шавар бигнүүрийн найрлаган дахь каолин шавар нь нүүрний илүүдэл тос болон бохирдлыг шингээдэг ба эрдэс элементийг ихээр агуулах тул арьсанд тэжээл өгч нүүрний арьсны булчинг амраах, арьсны нүх сүвийг багасгах зэрэг олон талын үйлчлэл үзүүлдэг. Иймээс олон төрлийн маскны суурь болгон хэрэглэдэг. Агарин нь тосны хүчлийн нийлэгжилтийг ихээр дарангуйлдаг (U.S.patent application Ser .No.11/029,861), хөлсний булчирхайг мэдээгүйжүүлж, хөлс ялгарлыг багасгадаг үйлчилгээтэй.



Компанийн зорилго:

Монгол орны түүхий эдийг ашиглан үндэсний бренд бүтээгдэхүүн шинээр бий болгох зорилготой.



Судалгааны багийн гишүүд:

Ц.Уранчимэг, ШУС-БУС, Хими, 4-р түвшин
Л.Дулмаа, ШУС-БУС, Хими, 4-р түвшин
Л.Халиун, ШУС-БУС, Хими, 4-р түвшин
Б.Батзаяа, ШУС-БУС, Хими, 4-р түвшин
Г.Батсугар, ШУС-БУС, Биологи, 4-р түвшин
О.Халиундарь, ШУС-БУС, Эдийн засаг, 4-р түвшин

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн байр 1-231 тоот

77307730 – 2435

smandakh@num.edu.mn



ГАРААНЫ МОН ГРИЙН ТАКАРА ХХК

Үүсгэн байгуулагч: Дэд профессор. Б. Даваапүрэв
ХШУИС-ийн Хими, биологийн инженерчлэлийн тэнхим

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА:

Манай компани нь дотоодын хэд хэдэн байгууллагуудтай (Нахиа эмийн үйлдвэр, Хавдар Судлалын Үндэсний Төв, Мал Эмнэлгийн Хүрээлэн, Нийслэлийн Шүд Эрүү Нүүрний Төв) хамтран ажиллахаас гадна гадаадын их дээд сургуулиудтай мөн хамтран ажилладаг.

АЛСЫН ХАРАА:

МУИС-ийн Ургамлын биотехнологийн лабораторийн багш, оюутнуудын судалгааны үр дүнд суурилсан, эрүүл мэнд, эмийн бүтээгдэхүүний шинэ санаа, санаачлалыг дэмжин хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэн, дотоодын эрүүл мэндийг дэмжих, импортыг орлох экспортод чиглэсэн бүтээгдэхүүний зах зээлийг эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр тогтмол хангахад оршино.



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Монгол орны биологийн нөөцийг ашиглан байгалийн гаралтай эм болон биологийн идэвхт бүтээгдэхүүний ирээдүйн хөгжлийг тодорхойлогч, шинийг санаачлагч, тэргүүлэгч байгууллага байж, хэрэглэгчдэдээ хамгийн чанартай, шинжлэх ухаанч мэдлэг шингэсэн, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэгч байна.

ХӨГЖҮҮЛЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

Ургамлын гаралтай "Uniqare" ам зайлагч бүтээгдэхүүн

Манай бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн амны хөндийн гол асуудлууд болох буйлны үрэвсэл, амны эвгүй үнэр, шүд цоорол, антибиотикт тэсвэржсэн бактерийн гаралтай архаг үрэвслийг арилгах үйлчилгээтэй цэвэр байгалийн гаралтай, шинэлэг бүтээгдэхүүн юм. Бүтээгдэхүүн нь таблеткан болон шингэн гэсэн төрөлтэй бөгөөд тэдгээр нь хэрэглэгчдийн хэрэглээний онцлогт нийцсэн хэлбэр, хэмжээтэй ч үйлчилгээний хувьд ижил байна. Одоогийн байдлаар зах зээлд нийлүүлэгдэж байгаа ижил нэр төрлийн бүтээгдэхүүнүүд дунд химийн аргаар гарган авсан ам зайлагч зонхилж байна. Химийн аргаар гарган авсан бүтээгдэхүүн нь бактер устгах үйлчилгээ сайн хэдий ч удаан хугацааны турш хэрэглэхэд амны хөндийн үрэвсэл үүсгэгч бактер нь уг бүтээгдэхүүнд тэсвэртэй болох хандлага нэмэгддэг учраас байгалийн гаралтай ам зайлагч бүтээгдэхүүн хэрэглэх шаардлага үүсдэг. Харин манай бүтээгдэхүүн ургамлын гаралтай учир бактерийн тэсвэржилтийг бууруулах боломжтой.

Хоолойны үрэвслийн эсрэг үйлчилгээтэй "АнтиПи" хүлхмэл

Энэхүү бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн хоолойн өвчлөлийн гол асуудлууд болох хоолойны хүнд болон хөнгөн үрэвслүүд тэр тундаа Монгол улсад түгээмэл тархсан "ангин" буюу хоолойны махны хүнд үеийн үрэвслийг үүсгэгч бактерийн голомтод хүрч үйлчилдэг цэвэр байгалийн гаралтай бүтээгдэхүүн юм. Энэхүү бүтээгдэхүүн нь хүүхэд болон том хүн, ангины эсрэг үйлчлэлтэй гэсэн гурван төрлөөр худалдаанд гарахаар төлөвлөгдөж байна.



Элэг хамгаалах эм болон шарталтын эсрэг бэлдмэл

Дараагийн бүтээгдэхүүн нь ургамлын гаралтай элэг хамгаалах эм болон шарталтын эсрэг бэлдмэл юм. Бидний хөгжүүлж буй гол бүтээгдэхүүн нь элэг хамгаалах эм бөгөөд шарталтын эсрэг бэлдмэл нь дагалдах бүтээгдэхүүн юм. Энэхүү бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгааг хийж гүйцэтгэсний дүнд Монгол улсын хэмжээнд маш өндөр хувьтай өвчлөлийн нэг болж буй элэгний өвчлөлийг эмчлэх болон урьдчилан сэргийлэх бүтээгдэхүүн гарган авах бөгөөд элэгний өвчлөлийг бууруулах, элэгний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.



Судалгааны багийн гишүүд:

Магистрант Т.Цэнгүүн, ХШУИС, Био-инженерчлэл хөтөлбөр
Магистрант Г.Намуунаа, ХШУИС, Био-инженерчлэл хөтөлбөр
Магистрант О.Ундармаа, ХШУИС, Био-инженерчлэл хөтөлбөр
Магистрант Д. Энхтуул, ХШУИС, Био-инженерчлэл хөтөлбөр
Оюутан Ү.Батмагнай, Бизнесийн Сургууль, 4-р түвшин
Оюутан Э.Бүрэнжаргал, Бизнесийн Ухааны Сургууль, 4-р түвшин
Оюутан Б.Бүжин, ХШУИС, Био-инженерчлэл хөтөлбөр, 4-р түвшин
Оюутан Д.Эрдэнэтуул, ХШУИС, Био-инженерчлэл хөтөлбөр, 4-р түвшин
М.Номуундарь, Нахиа эмийн үйлдвэрийн микробиологич

Холбоо барих мэдээлэл

МУИС, Номын сан 506 тоот

99240573, 89443484, 86776700

davaapurev@seas.num.edu.mn
eenienkhtuul@gmail.com
und.otg@gmail.com